

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

2000–2001 хичээлийн жил:

- ✓ Байгаль орчны сайд асан Доктор Ц.Адъяасүрэн, мөн яамны ажилтан Л.Эрдэнэтөгс, ахмад ажилтан Л.Батбилэг нар анх санаачлан Эко Ази Байгаль орчны дээд сургуулийг 2000 онд үүсгэн байгуулав.
- ✓ Доктор Ц.Адъяасүрэн өөрийн ажиллаж байсан Засгийн газрынхаа эдийн засаг-нийгмийн шинэчлэлтийн бодлогын хүрээнд эхлүүлсэн “Байгалийг ашиглагч нь хамгаалах - User Pay Principle “ шинэчлэлийн зарчимаа өөрийн үүсгэн байгуулсан сургуулийнхаа оюутануудаар дамжуулан хэрэгжүүлэх зорилго агуулсан болно.
- ✓ Доктор Ц.Адъяасүрэн боловсруулж тодорхойлсон шинэтгэлийн бодлого, дэлхийн хэмжээний хүрээлэх орчны дэвшилтэт технологийг оюутнууддаа зааж сурган байгаль орчны салбарын хүний нөөцийг шинэ агуулгаар бүрдүүлэх боллоо.

ЭКО АЗИЙН УРИАЛГА:

Байгаль орчны бодлогыг ЭКО АЗИ БОМДС тодорхойлно.

Байгаль орчны менежментийг ЭКО АЗИ-ийнхан хийнэ.

Бид чадна. Бид чадвартай.

Бид Монголын байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хүрээлэх орчныг хамгаална.

Байгаль орчин-эдийн засаг-нийгмийг нэгдмэл бодлогоор хөтлөнө.

Монгол улсад Тогтвортой –Ногоон хөгжлийн бодлого боловсруулж, төлөвшүүлнэ.

- ✓ Шалгаруулалт хийж багш нарын баг бүрдүүлэв.
- ✓ Анхны элсэлтээ авч, анхны хичээлийн жилийн нээлтээ хийхэд Ц.Адъяасүрэнгийн удирдаж байсан Байгаль орчны яамны хамт олон нь оролцож баяр хүргэн халуун дотно дэмжиж байлаа.
- ✓ Байгаль орчны салбарын тэргүүлэх эрдэмтдээс бүрдсэн Эрдмийн зөвлөл байгуулав.
- ✓ Сургуулийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө чиглэлийг тогтоож Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулав.
- ✓ Байгаль орчны байцаагчийн эчнээ анги нээх бэлтгэл ажлыг хийлээ.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн Япон улсын “Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэн”-гийн Удирдах зөвлөлийн гишүүнээр 12 жилийн хугацаатай сонгогдов.

- ✓ Ийнхүү Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны менежментийн болон тогтвортой хөгжлийн бодлого, хүрээлэх орчинд ээлтэй шинэ технологийн дээжийг ЭКО АЗИ дээд сургууль хүртэх боломжтой боллоо.

2001–2002 оны хичээлийн жил:

- ✓ Эко Ази дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж БСШУЯ-аар батлуулав.
- ✓ Сургуулийн багш, оюутнууд Дэлхийн улс орнуудад түгсэн “Озоны түүхээс”, “Газар хөрсний элэгдлийг юугаар ч анагааж чадахгүй гэж үү” зэрэг номуудыг англи хэлнээс өөрсдөө орчуулж хэвлүүлэв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн санаачлан НҮБ-аас гаргасан “Гамшгийн менежмент” сурах бичгийг Л.Болдбаатараар орчуулуулан , захирал редакторлан хэвлүүлэв.
- ✓ “Байгаль орчин, озоны давхаргаа хамгаалъя” сэдэвт олимпиадыг Монголын үндэсний телевизтэй хамтран анх удаа зарлаж зохион байгуулав.
- ✓ Багш нарынхаа хийсэн судалгааны ажилд үндэслэн “Environmental Monitoring & Management Paper’s” хэмээх сургуулийн анхны бүтээлийг бэлтгэн гаргав.
- ✓ Сургууль дээр анх удаа НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөртэй хамтран “Озоны давхрагыг хамгаалах олон улсын семинар” зохион байгуулав.
- ✓ Голландын EARS–тай хамтран “Монгол орны байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийн систем” төслийн эхний хувилбарыг боловсруулав.
- ✓ Японы Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэнгийн захиалгаар “Монгол орны экологийн боловсролын үнэлгээ” сэдэвт судалгааг хийж явуулав.
- ✓ “ЭКО АЗИ” дээд сургууль TPN “Цөлжилттэй тэмцэх конвенцийн Азийн бүсийн сүлжээг хариуцах байгууллага” болов.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэнгийн урилгаар Голланд улсаас Монгол улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхэт Элчин сайд Филипп де Хеер тус сургуульд зочилж цаашид хамтран ажиллах чиглэлийг тохиролцов.

2002–2003 оны хичээлийн жил:

- ✓ Тус сургуулиас хэвлүүлэх сурах бичгүүдийн ерөнхий чиглэлийг боловсруулав.
- ✓ Ц.Адъяасүрэн нарын судлаачид “Зайнаас тандан судлал, газар зүйн мэдээлэлийн систем” сурах бичгийг бичиж, хэвлүүлэв.Хэд хэдэн удаа хэвлэгдэв.
- ✓ Оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн уралдааныг анх удаа санаачлан зарлаж, дүгнэн шалгаруулав.

- ✓ ШУА-ийн “Эдийн засгийн хөгжлийн хүрээлэн”-гийн захиалгаар тус сургуулийн судлаач багш нар “Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ” төслийн судалгааг гүйцэтгэж, тайланг боловсруулж хүргүүлэв.
- ✓ Швейцарын SARMAP/Экологи байгууллагатай хамтран “Монгол орны мал аж ахуйн эрсдэл” төслийн судалгааг эхлүүлэв.
- ✓ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр захирал доктор Ц.Адъяасүрэн, эдийн засагч - доктор М.Энхсайхан нарын удирдсан баг “Тогтвортой хөгжил” сурах бичгийг зохиож хэвлүүлэв.
- ✓ “Байгаль орчин озоны давхаргаа хамгаалъя” сэдэвт телевизийн 2 дахь уламжлалт олимпиад зарлаж зохион байгуулав.
- ✓ ТРН “Цөлжилттэй тэмцэх конвенцийн Азийн бүсийн сүлжээний анхны семинарыг Улаанбаатар хотод зохион байгуулав.
- ✓ Японы Байгаль орчны стратегийн хүрээлэнгийн захиалгаар “Монгол орны экотуризмын үнэлгээ, хөгжил” сэдэвт судалгааг хийж явуулав.
- ✓ Голландын элчин сайдын яаманд хандан “Байгаль орчны менежемент, тогтвортой хөгжил” сэдвээр багш нар, судлаачдыг давтан сургах төсөл боловсруулан явуулав.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэнгийн урилгаар Байгаль орчны сайд У.Барсболд, сайд асан Л.Нямсамбуу нар тус сургуульд зочлов.

2003–2004 оны хичээлийн жил:

- ✓ Доктор Л.Нацагдорж зохиож, доктор Ц.Адъяасүрэн хянан тохиолдуулж “Байгаль орчны мониторинг” хичээлийн сурах бичгийг хэвлүүлэв.
- ✓ Ц.Адъяасүрэн, Д.Батбаяр “Байгаль орчны аудит” сурах бичиг зохиож түүнийг цахим хэлбэрээр багш, оюутнууд ашиглах боллоо.
- ✓ Оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 2 дахь уралдааныг зарлаж, шалгаруулав.
- ✓ Сургууль дээрээ анх удаа оюутнуудын дунд “Миний сонгосон мэргэжил” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, шалгаруулав.
- ✓ Сургууль дээрээ анх удаа оюутнуудын дунд “Англи хэлний олимпиад” зохион байгуулж, шалгаруулав.
- ✓ Сургуулийн багш, судлаачдын бүтээлээр “Байгаль орчны мониторинг, менежмент” хоёр дахь бүтээлийг боловсруулав.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэнгийн урилгаар Монгол улсын анхны ерөнхийлөгч доктор, проф. П.Очирбат тус сургуульд зочилж хүндэтгэлийн лекц уншив.
- ✓ “Шинэ зууны лекцийн индэр”-ийг анх удаа санаачлан эхлүүлж сургуулийн захирал доктор, проф.Ц.Адъяасүрэн, Монгол улсын анхны ерөнхийлөгч доктор, проф.П.Очирбат, Японы Цукубагийн их сургуулийн проф.М.Сугита, УИХ-ын гишүүн Ц.Шийрэвдамба, Байгаль орчны сайд У.Барсболд нарын зэрэг хүмүүс лекц уншив

- ✓ Багш нарын эрдэм шинжилгээний онолын семинарийн чиглэлийг тогтоов.
- ✓ Японы Цукубогийн их сургуультай хамтран “Хээр нутгийн бэлчээр ус–агаар мандал экосистем”-ийн судалгааны төсөл эхлүүлэв. Хээрийн судалгааны ажилд багш И.Бямбахүү, оюутан Ц.Мөнхбат, С.Эрдэнэцогт, Л.Адилбиш нарын зэрэг оюутнууд оролцов.
- ✓ АХБ, “Шар шороон шуурганы мастер төлөвлөгөө” боловсруулахад багш нар оролцов.
- ✓ НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай гэрээ байгуулан “Монгол орны байгаль орчин, байгалийн нөөцийн ГАРЦ (GATEWAY)” төслийг хэрэгжүүлэн интернэтийн сүлжээнд суулгав.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн АНУ-ын American Biographical Institute намтар судлалын хүрээлэнгээс “21 дүгээр зууны суу билэгтэн” өргөмжлөл хүртэв.
- ✓ Голландын Маастрихтын менежментийн дээд сургуульд “Байгаль орчны менежемент, тогтвортой хөгжил” сэдвээр багш нар, судлаачдыг давтан сургах төслийн хүрээний сургалтанд 2004 оны 10-12 дугаар сард багш нар хамрагдав.

2005–2006 оны хичээлийн жил:

- ✓ Сургууль 13 дугаар хороололд өөрийн шинэ байрандаа нүүж оров.
- ✓ Германы хамтын ажиллагааны шугамаар 2005 оны 8 дугаар сарын 8-24-нд их дээд сургуулиудын дунд зохион байгуулсан сургалтанд багш, оюутнууд оролцож “Газар зохион байгуулалтын ангийн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр” боловсруулах ажлыг хийв.
- ✓ Тус сургууль БСШУЯ-ны аттестатчилалд хамрагдаж амжилттай дүн үзүүлэв.
- ✓ Сургуулийг хөгжүүлэх 4 жилийн стратегийн чиглэл, төлөвлөгөөг боловсруулж батлав.
- ✓ Солонгос улсын хөгжлийг дэмжих сангийн тэтгэлэгт тус сургуулийн оюутанууд хамрагдаж эхлэв.
- ✓ Сургуулийн бүтцийг шинэчлэн боловсруулав.
- ✓ Оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 3 дахь удаагийн уралдааныг уламжлал болгон зарлаж, шалгаруулав.
- ✓ “Шинэ зууны лекцийн индэр”-ийг үргэлжлүүлэн, сургуулийн захирал доктор, проф. Ц.Адъяасүрэн, Японы Сокогийн их сургуулийн проф.Ивата, Японы Яаманачи мужийн “Нөөцийг дахин ашиглах төв”-ийн захирал доктор Курода нарын зэрэг эрдэмтэд лекц уншив.
- ✓ Ази, Номхон далайн улс орнуудын “Байгаль орчны салбарын нэрт эрдэмтэдийн олон улсын симпозиум”-д сургуулийн захирал доктор, проф. Ц.Адъяасүрэн, Монгол улсаа төлөөлөн оролцож “Дэлхийн байгаль орчны хувирал өөрчлөлт Монгол орны байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

- ✓ Тайванд зохион байгуулсан “Агаар мандлыг хамгаалах олон улсын хамтын ажиллагаа” бага хуралд захирал доктор, проф. Ц.Адъяасүрэн, Гүйцэтгэх захирал А.Ган-өлзий нар оролцож “Монгол улсад агаар хамгаалах арга хэмжээ, бодлого” сэдвээр илтгэл тавив.
- ✓ Монгол улсын тогтвортой хөгжлийн боловсролын судалгаа хийж, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Азийн бүсийн төвд явуулав
- ✓ Ус цаг уурын хүрээлэн, Японы Цукубогийн их сургуультай хамтран зохион байгуулсан “Хээр нутгийн бэлчээр ус–агаар мандал экосистем”–ийн судалгааны төслийн үр дүнгийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд тус сургуулийн багш нар илтгэл хэлэлцүүлэв.
- ✓ Голландад “Байгаль орчны менежемент, тогтвортой хөгжил” сэдвээр багш нар, судлаачдыг давтан сургах төслийн сургалтанд 2005 оны 5-6 дугаар сард тус сургуулийн багш Ц.Адъяасүрэн, А.Ган-Өлзий, Г.Чулуунцэцэг нарын зэрэг олон багш, судлаачид бусад ажилтнууд оролцов.
- ✓ Голландад Маастрихтын их сургуультай хамтран улс орныхоо байгаль орны менежментийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Байгаль орчны менежмент, тогтвортой хөгжил” сэдвээр төрийн яамд, агентлагууд болон бизнесийн байгууллагын ажилтнуудад зориулан сургалт-семинарыг 2005 оны 9 дугаар сард зохион байгуулав.
- ✓ БНХАУ-д болсон “Тогтвортой хөгжлийн боловсролын дэлхий дахины арван жилийн нээлтийн олон улсын бага хуралд “Монгол улсаа төлөөлөн Захирал Ц.Адъяасүрэн оролцож “Тогтвортой хөгжлийн боловсрол Ази тив ба Монгол улсад” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.
- ✓ Цөлжилттэй тэмцэх конвенцийн Азийн бүсийн сүлжээний түүхэн замналын хураангуйг боловсруулан Байгаль орчны яаманд хүргүүлэв.
- ✓ Сургуулийнхаа 5 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв. Багш Ц.Адъяасүрэн “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, багш Д.Содном “Үйлдвэр, худалдааны тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр шагнуулав.

2006 – 2007 оны хичээлийн жил:

- ✓ “Эко Ази” байгаль орчин, менежментийн дээд сургууль бүрэлдэхүүнээсээ салбар сургууль гаргаж бие даалган ажиллуулж эхлэв.
- ✓ Сургуулийг хөгжүүлэх 4 жилийн стратегийн чиглэл, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлав.
- ✓ Тус сургуулийн оюутнууд Швейцарийн хөгжлийн агентлаг, “Зориг сан”-гийн оюутны тэтгэлэгт хамрагдаж эхэллээ.
- ✓ Германы хамтын ажиллагааны шугамаар 2006 оны 8 дугаар сард газрын харилцааны их дээд сургуулиудын дунд зохион байгуулсан сургалтанд багш, оюутнууд оролцов.

- ✓ Тус сургуулийн Удирдах зөвлөлийн дарга доктор **Д.Түвдэндорж** Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “**Монгол улсын Байгаль орчны гавъяат ажилтан**“ цол хүртэв.
- ✓ Монголын оюутны холбоотой хамтран оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 4 дахь удаагийн уралдааныг “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр уламжлал болгон зарлаж, шалгаруулав.
- ✓ “Зууны лекцийн индэр” сэдвийн хүрээнд лхагва гариг бүрт байгаль орчны салбарын нэрт эрдэмтэд, доктор, профессоруудыг урьж багш, оюутнуудад лекц уншуулдаг болов.
- ✓ Сургуулийн багш, судлаачдын бүтээлээр “Байгаль орчны мониторинг, менежмент” гурав дахь бүтээлийг англи хэл дээр цахим хэлбэрээр гаргав.
- ✓ Японы Тогтвортой хөгжлийн боловсролын төвийн урилгаар захирал Ц.Адъяасүрэн Японы Ёосика хотод очиж олон улсын хуралдаанд оролцов.
- ✓ Японы Мие мужийн “Байгаль орчны технологи дамжуулах олон улсын төв” тус сургуультай “Байгаль орчны менежментийн салбарт хамтран ажиллах санамж бичиг” -т гарын үсэг зурав.
- ✓ Японы Мие мужийн “Байгаль орчны технологи дамжуулах олон улсын төв”-ийн (International Center for Environmental Technology Transfer-ICETT, “Training Course on Environmental Management for Local Government Officials in Mongolia, Environmental Cooperation Program for Asia”) төсөлд хамрагдаж нийслэл Улаанбаатар хотынхоо байгаль орчны менежментийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн байгаль орчны асуудал эрхэлсэн ажилтнуудыг Япон улсад 3 долоо хоногийн сургалтанд оролцуулав.
- ✓ TUNZA/UNEP НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн үүсгэлтэй хүүхэд залуучуудын байгаль орчны “ТУНЗА” олон улсын сүлжээнд гишүүнчлэлээр хамрагдан орж үйл ажиллагаа явуулж эхлэв.
- ✓ Гүйцэтгэх захирал А.Ган-Өлзий Японы Мие мужийн “Байгаль орчны технологи дамжуулах олон улсын төв”-д дадлага хийв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс “Байгаль орчин, озоны давхрагыг хамгаалах нэрт зүтгэлтэн ” цол, өргөмжлөл хүртэв.
- ✓ Тус сургуулийн захирал Ц.Адъяасүрэн Изриаль улсын Бен Гуроны нэрэмжит Улсын их сургуульд “Монгол орны уур амьсгалын өөрчлөлт ба цөлжилтийн хандлага” сэдэвт лекц уншив.
- ✓ Эко Ази БОМДС нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн дэргэдэх “Цэвэр үйлдвэрлэлийн үндэсний төв”-ийн үүсгэн байгуулагч гишүүн болов.
- ✓ Эко Ази БОМДС нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимийн “GREEN EXCELLENCE” өргөмжлөл хүртэв.

2007–2008 оны хичээлийн жил:

- ✓ Японы Ёккайчигийн их сургууль “ЭКО АЗИ” БОМД сургуультай “Оюутны зуны хамтарсан сургалт зохион байгуулах хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.
- ✓ Японы Ёккайчигийн их сургуулийн оюутнуудтай хамтран Улаанбаатар хотод хоёр их, дээд сургуулийн “Оюутны зуны сургалт”-ыг анх удаа амжилттай зохион байгуулав. Хамтарсан эрдэм шинжилгээний бага хуралд Эко Ази дээд сургуулийн 6 оюутан илтгэл хэлэлцүүлж, хамтран хээрийн судалгаа хийж, явган аялалд оролцож, спорт-урлагийн арга хэмжээ зохион байгуулав.
- ✓ Германы хамтын ажиллагааны шугамаар 2007 оны 8 дугаар сард Газрын харилцааны их дээд сургуулиудын дунд зохион байгуулсан сургалтанд багш, оюутанууд оролцов.
- ✓ Сургалтын албаны менежер Г.Чулуунцэцэг, багш Г.Довчиндорж нар Японы Мие мужийн “Байгаль орчны технологи дамжуулах олон улсын төв”-д дадлага хийв.
- ✓ Монголын оюутны холбоотой хамтран оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 5 дахь удаагийн уралдааныг “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр доктор, проф. Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит болгон зарлаж, шалгаруулав
- ✓ Сангийн яам, “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт”, Үндэсний хоёр дахь тайлан. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах хэсгийг боловсруулав.
- ✓ Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Мянганы хөгжлийн бодлогод суурилсан Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого”, Байгаль орчны бүлгийг тус сургуулийн багш нар бичив.
- ✓ УБ ЗДТГ, “Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-ний ажлын хэсэгт багш нар оролцов.
- ✓ Тус сургуулиас Баянзүрх дүүргийн “Байгаль орчны мастер төлөвлөгөө”-г боловсруулахад туслалцаа үзүүлэв.
- ✓ БОЯ, WB, Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэлгээг багш нар хийв.
- ✓ БОЯ, “Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх төслийн-“Монгол улсад Байгаль орчны менежментийг хэрэгжүүлэх удирдлага, зохицуулалтын тогтолцоо” судалгааны тайланг багш нар боловсруулж холбогдох газруудад явуулав.
- ✓ Эко Ази БОМДС нь Баянзүрх дүүргийн **2007 оны тэргүүний байгууллагаар** шалгарч, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнуулав.

2008–2009 оны хичээлийн жил:

- ✓
- ✓
- ✓ Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт оюутны дадлагын хичээлийн полигонтой болж хээрийн дадлага хийж эхлэв.
- ✓ Япон Миегийн их сургуультай хамтран “Их дээд сургуулийн байгаль орчны менежмент” төслийг хоёр сургуулийн оюутан, багш нарын дунд хамтран хэрэгжүүлж эхлэв. Төслийн хүрээнд Миегийн их сургуулийн проф.Оно Парк багш, оюутануудад лекц уншиж, Улаанбаатар хотын агаар, усны бохирдлын судалгаа, үнэлгээний ажлыг багш нар хамтран хийв.
- ✓ Монголын Оюутны Холбоотой хамтран доктор, проф. Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит уламжлалт оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 6 дахь удаагийн уралдааныг “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр зарлаж, шалгаруулав
- ✓ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, БОАЖЯ-ны “Байгаль орчны засаглал” төсөлтэй хамтран “Байгаль орчны аудитын сургалт, семинарыг төр, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын ажилтануудад зориулан 3 удаа зохион байгуулав. Ийнхүү тус сургууль нь санаачлан анх удаа Монгол улсын хэмжээнд “Байгаль орчны аудит”-ын ажлыг эхлүүлэх суурийг тавьсан болно.
- ✓ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, БОАЖЯ-ны “Байгаль орчны засаглал” төслийн захиалгаар “Байгаль орчны аудитын туршилт”- ыг Өвөрхангай аймгийн Уянга сумын алтны уурхай, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 удаа хийхэд тус сургуулийн багш нар оролцов.
- ✓ Тус сургуулийн багш нар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, БОАЖЯ-ны “Байгаль орчны засаглал” төслийн захиалгаар “Байгаль орчны аудитын гарын авлага” боловсруулж хэвлүүлэв.
- ✓ БОАЖЯ, ДБХС, “Тусгай хамгаалалтай газар нутгийн менежмент, санхүүгийн хэрэгцээний үнэлгээ” хэмээх судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.
- ✓ БОЯ, Нидерландын Засгийн газар, Нээлттэй нийгмийн хүрээлэнгийн “Байгаль орчны сэтгүүлч” төсөлт ажлыг гүйцэтгэж төвийн хэвлэл мэдээлэлийн 40 гаруй байгууллагын ажилтнуудад байгаль орчны бодлого, үйл ажиллагааны талаар 24 сэдэв, чиглэлээр хичээл заасан нь Сэтгүүлчдийн холбооны удирдлагаас талархал хүлээсэн байна. Клубын хаалтын ажиллагаанд Сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч Т.Баасансүрэн, нэрт сэтгүүлч Д.Цэмбэл нар оролцсон болно.
- ✓ “Байгаль орчны сэтгүүлчийн гарын авлага”, “Байгаль орчны сэтгүүлчийн лавлах” номуудыг хэвлэн гаргаж түгээв.
- ✓ Дэлхийн хүн төрөлхтөний нийтлэг эрх ашгийг хамгаалах үйлсэд өндөр хувь нэмэр оруулсан тул Захирал Ц.Адъяасүрэн ”АНУ–ын Байгаль орчны

агентлагын хүндэт шагнал “Хүрээлэх орчин, озоны давхрагыг хамгаалах хүндэт өргөмжлөл” хүртэв.

- ✓ Японы Дэлхийн байгаль орчны стратегийн хүрээлэнгийн “Multi-stakeholder partnership building to promote education for sustainable development in Mongolia” төсөлт ажлыг хэрэгжүүлэв. Тус сургуулиас Хустайн нурууны байгаль орчны цогцолборт газрын мэдээлэл сурталчилгааны төвд ТХГН-ийн менежментийн самбар- зурагт үзүүлэн хийж өгөв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн Баянзүрх дүүргийн 2008 оны “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарав.
- ✓ ОБЕГ, НҮБ ХХ, “Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийг стратеги” төсөлт ажилд оролцов.
- ✓ Монгол улсын Ерөнхийлөгч, Ногоон намын санаачилсан “Уур амьсгалын эсрэг хамтдаа” компанит ажилд оролцов.

2009–2010 оны хичээлийн жил:

- ✓ Эко Ази Байгаль орчин менежментийн дээд сургуулийн ЭБХ ангид элсэгч Г.Золбоо Дорнод аймгийн Баян-Уул сумын 10 настай жаал хүү Эрээний нурууны өвөр бэл Өвөр Дархинт орчимд морьноосоо унан төөрч Эрээний нурууг Өнөрчийн даваа орчимоор явганаар даван ой хөвчид ганцаархнаа хоол ундгүй бүтэн 11 хоног маш хүнд бэрхийг даван туулаад эцсийн хүчээ шавхан тэмцэж Дэгэн Жигэний доод гацаа Онон мөрний урд эргэн дээр байх үед нь Онон голын хойд эргээр Амарын хилим загасны хайгуулын ажил хийж байсан Дадал сумын загасчдын клубын ахлагч Г.Золбоо, загасчдын клубын гишүүн Ч.Алтангэрэл нар олж Онон мөрнийг сэлэн гаталж очиж аварлаа.
- ✓ Оюутнуудын дунд сэдэвчилсэн дугуйлангууд зохион байгуулж ажиллуулав.
- ✓ МУИС, МУБИС–иудтай хамтран SIDA Шведийн хөгжлийн сангийн дэмжлэгээр “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийг хэрэгжүүлж эхлэв. Төслөөр тус сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох арга хэмжээ авав.
- ✓ Эко Ази Байгаль орчин менежментийн дээд сургуулийн ЭБХ-4 ангийн оюутан оюутан Б.Сансар
- ✓ Японы Миегийн их сургуульд захирал Ц.Адъяасүрэн, багш Ж.Баянмөнх нар “Зүүн хойд Азийн улс орнуудын Их сургуулиудын эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа” уулзалт, симпозиумд оролцож илтгэлүүд хэлэлцүүлэв.
- ✓ Японы Миегийн их сургуулиас зохион байгуулсан Зүүн хойд Азийн 5 улс орны 15 их сургуулиудын багш нарын уулзалтанд захирал доктор, проф. Ц.Адъяасүрэн” Тогтвортой хөгжлийн боловсрол ба Монгол уламжлал” сэдвээр лекц уншив.

- ✓ SIDA Шведийн хөгжлийн агентлагаас МУИС, МУБИС, Эко Ази БОМС–д хэрэгжүүлж байгаа “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд “Тогтвортой хөгжлийн боловсролыг сургалтын агуулгад нийцүүлэх” судалгааг Гүйцэтгэх захирал А.Ган-Өлзий гүйцэтгэж, холбогдох хөтөлбөрийг боловсруулахад оролцов.
- ✓ Монголын Оюутаны Холбоотой хамтран доктор, проф. Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит уламжлалт оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 7 дахь удаагийн уралдааныг “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр зарлаж, шалгаруулав. Тус уралдаанд Улаанбаатар хотын 10 их, дээд сургуулийн 50 гаруй оюутнууд 34 илтгэл хэлэлцүүлсэн байна.
- ✓ Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Усны газраас зохион байгуулсан “Ус хөгжлийн тулгуур” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хуралд ГЗБ-ын ангийн оюутан Энхтөрийн илтгэлүүд 2, 3 дугаар байр эзлэв.
- ✓ Тус сургуулийн Зөвлөх багш **Ц.Дамдин** Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “**Монгол улсын Байгаль орчны гавъяат ажилтан**” цол хүртэв.
- ✓ БНСУ-ын “ЕСО Peace” байгууллага ЭКО АЗИ БОМД сургуультай “Дашинчилэн сумын тогтвортой хөгжлийн стратеги боловсруулах талаар хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурав.
- ✓ БОЯ, “Байгаль орчны аудитын эрх зүйн үндэс, холбогдох журмын төсөл” боловсруулж хүргүүлэв.
- ✓ Сургуулийн шинэ вэб хуудасны дизайн боловсруулж вэбийг бэлэн болгов.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Монголын эдийн засгийн чуулга уулзалт”-д оролцож Ус, уур амьсгалын өөрчлөлт, хотын хүрээлэх орчин, ногоон эдийн засаг гэсэн 3 цуврал хуралдаанд илтгэгчээр ажиллав.
- ✓ АНУ–ын “Н&J” байгууллага АХБ–ны “Дулааны цахилгаан станцуудаас үүсэх хил дамжсан агаарын бохирдлыг бууруулах нь” төсөлд хамтран ажиллах талаар ЭКО АЗИ БОМД сургуультай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурав.
- ✓ Италийн “Ambienta” Environmental Assets байгууллага тус сургуультай “Ногоон эдийн засгийг хөгжүүлэх” талаар хамтран ажиллах санамж бичиг байгуулав.
- ✓ БОАЖЯ-ны Ойн газар, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын “Ойн менежмент” төсөлтэй хамтран хамтын эзэмшлийн ойн менежментийн агуулгаар “Ойн хичээл”-ийн хөтөлбөрийг өргөжүүлж, холбогдох гарын авлага, сурах бичиг зохиох, чадавхийг бий болгох талаар “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж үйл ажиллагааг хэрэгжүүлэв.
- ✓ Эко Ази Байгаль орчин менежментийн дээд сургуулийн ЭБХ-3 ангийн оюутан Б.Сансар 100 хоногт Монгол орноороо тойрон ганцаарчилсан аялал

хийж хүрэлцэн ирлээ. Тус сургуулийн удирдлага, багш, оюутнуудын төлөөлөл тосон авч баяр хүргэлээ.

- ✓ НХХЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, “Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл-2010, Уур амьсгалын өөрчлөлт ба хүний хөгжил илтгэл бэлтгэв.
- ✓ БОАЖЯ, ШУА, Геоэкологийн хүрээлэн, “Байгаль орчны мастер төлөвлөгөө”, Тогтвортой хөгжлийн боловсролын бүлэг, Байгаль орчны менежмент, Байгаль орчны аудит, байгаль орчны зөвшөөрөл, стандартын бүлэг бичив.
- ✓ Монгол улсын Засгийн газар, “Утаагүй Улаанбаатар” хөтөлбөр, хот байгуулалт, дэд бүтэц, эрчим хүчний хэсэгт тус сургуулийн багш нар оролцов.
- ✓ RAMSAR SMALL GRANTS FUND FOR WETLAND CONSERVATION AND WISE USE (SGF), “Community-based Wetland Ecosystem Management for Lake Terkhiin Tsagaan Nuur Ramsar wetland in Mongolia” төсөлт ажлыг гүйцэтгэж байна.
- ✓ БНСУ-ын Eco peace Asia, Korea, “Булган аймгийн дашинчилэн сумын тогтвортой хөгжил” төслийн мэдээ цуглуулах, хээрийн судалгаа хийх төсөлт ажилд оролцож байна.

2010–2011 оны хичээлийн жил:

- ✓ Захирал Ц.Адъяасүрэн. “Монгол улсын Эдийн засгийн форум”-д оролцож ус хамгаалах асуудлаар ярилцлага өрнүүлэв.
- ✓ Эко Ази дээд сургууль санаачилж Монгол улсад анх удаа “Байгаль орчны аудит”-ын ажлыг эхлүүлэв.
- ✓ “Байгаль орчны аудит”-ын ажлын журмыг боловсруулж БОЯ-аар батлуулав.
- ✓ “Байгаль орчны аудит”-ын цуврал сургалтыг зохион байгуулав.
- ✓ АХБ-ны “Азийн орнуудын хил дамнасан агаарын бохирдол” сэдэвт судалгааны төсөлт ажлыг гүйцэтгэв.
- ✓ ШУА-ын эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд Ц.Адъяасүрэн. “Сэлэнгийн сав газрын тогтвортой хөгжил” сэдэвт илтгэлээр оролцож 3 дугаар байр эзлэв.
- ✓ Эко Ази дээд сургуулийн 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.
- ✓ Сургуулийн өнгөрсөн 10 жилийн сургалтын үйл ажиллагаанд анализ, үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөр, стандартаа сайжруулан боловсруулах ажлыг хийв.
- ✓ Японы Миегийн их сургуульд захирал Ц.Адъяасүрэн, МУИС-ийн захирал С.Төмөр-Очир нар оролцож “Зүүн хойд Азийн улс орнуудын Их сургуулиудын эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа “ уулзалт, симпозиумын нээлтэнд үг хэлэв.
- ✓ Японы Миегийн их сургуулиас “НҮБ-ын Биологийн төрөл зүйл”-ийн конвенцийн талуудын 10 дугаар бага хуралд зориулсан Зүүн хойд Азийн 5

улс орны 15 их сургуулиудын багш нарын их, дээд сургуулиудын симпозиумд захирал доктор, проф. Ц.Адъяасүрэн “Монголын биологийн төрөл зүйл, хамгаалах стратеги” хэмээх илтгэлийг хэлэлцүүлэв.

- ✓ Монголын Оюутны Холбоотой хамтран доктор, проф. Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит уламжлалт оюутаны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 8 дахь удаагийн ЭШБХ-ыг сургуулийн 10 жилийн ойд зориулан “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр зарлаж, шалгаруулав. Тус уралдаанд Улаанбаатар хотын 12 их, дээд сургуулийн 50 гаруй оюутанууд 34 илтгэл хэлэлцүүлсэн байна.
- ✓ Сургуулийнхаа 10 жилийн ойд зориулан оюутан, багш нар, иргэдэд зориулан мэргэжлээ сурталчлах өдөрлөгийг “Газар зохион байгуулалт”, “Байгаль орчны үнэлгээ”, Байгаль хамгаалал, эрх зүй”, “Байгалийн аялал жуулчлал” сэдвээр тусгай хөтөлбөрүүдтэй зохион байгуулж давхардсан тоогоор нийт 1000 гаруй хүмүүс оролцов.
- ✓ Сургуулийнхаа 10 жилийн ойд зориулан “Номын баяр”-г тусгай хөтөлбөрөөр хийж шинээр гаргасан 4 номыг эх барьж авав. “Номын баяр”-т ШУА-ын Ерөнхийлөгч асан академич Б.Чадраа, Төрийн соёрхолт яруу найрагч, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, Соёлын гавъяат зүтгэлтэн Д.Шагдарсүрэн, Байгаль орчны гавъяат ажилтан, Удирдах зөвлөлийн дарга доктор Д.Түвдэндорж, Байгаль орчны гавъяат ажилтан, сайдын зөвлөх Ц.Дамдин нарын олон хүмүүс оролцож ерөөлийн үг айлдаж, яруу найргийн хур буулгав.
- ✓ Сургуулийнхаа 10 жилийн ойд зориулан “Тогтвортой хөгжил- Байгаль орчны менежмент” сэдэвт салбар дундын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав.
- ✓ Сургуулийнхаа 10 жилийн ойн баярын хурлыг зохион байгуулж БОАЖ-ын дэд сайд Ч.Жаргалсайхан, Газрын дарга А.Намхай, БСШУЯ-ны ажилтан Батсайхан, МҮХАҮТ-ийн дэд дарга Янсанжав, МОХ-ны нарийн бичгийн дарга Батжаргал, ШУА-ын дэд ерөнхийлөгч Дорж нарын зэрэг албаны хүмүүс оролцож, баяр хүргэж тус сургуулийн багш, оюутнууд, ажилтан нарыг төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хүндэт шагналаар шагнав.
- ✓ Сургуулийнхаа 10 жилийн ойд зориулан БСШУ-ны сайдын Өргөмжлөл, БОАЯ-ын сайдын мэндчилгээ, ШУА-ын Ерөнхийлөгчийн талархал, МҮХАТ-ын даргын мэндчилгээ, МОХ-ны талархал зэрэг шагналыг тус сургууль хүлээн авлаа.
- ✓ Сургуулийн 10 жилийн ойгоор МОХ-ны шагналаар оюутан Пүрэвжамц, Энхтөр нар, БОАЖ-ын Тэргүүний ажилтан цол, тэмдэгээр тус сургуулийн Гүйцэтгэх захирал А.Ган-Өлзий, сургалтын албаны менежер Г.Чулуунцэцэг, “Хүндэт жуух бичиг”-ээр багш А.Эрдэнэбаяр, СЯ-ны “Санхүү-банкны тэргүүний ажилтан” цол тэмдэгээр санхүүч, ня-бо Г.Сэлэнгэ, Залуучуудын

холбооны “Тэргүүний залуу” медалиар багш Ж.Баянмөнх, ХХХААЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр багш Ч.Заяа нарын олон багш нар тус тус шагнуулсан болно.

- ✓ Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Усны газраас зохион байгуулсан “Ус хөгжлийн тулгуур” сэдэвт оюутны эрдэм шижилгээний бага хуралд оюутан Сансар, Пүрэвжамц, Энхтөрийн илтгэлүүд 2 дугаар байр болон тусгай шагнал хүртэв.
- ✓ Дэлхийн банктай хамтран “Орон нутгийн байгаль орчны чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтын төслийг тус сургуулийн баг хэрэгжүүлж, Ховд, Өмнөговь, Увс аймгуудын БОАЖГ, ТХГН, МХЕГ-ын ажилтан нарт зорулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, БОАЖЯ-аар батлуулав. Сургалтын хөтөлбөр боловсруулах судалгааг хийх, хөтөлбөрийн санааг дэвшүүлэх ажилд оюутан Пүрэвжамц, Энхээ, захирал багш Ц.Адъяасүрэн, А.Эрдэнэбаяр, Ч.Заяа, Б.Мягмаржав, Д.Энэбиш нар оролцов.
- ✓ Сургалтын дадлагыг Горхи-Тэрэлжийн полигон, үйлдвэрлэлийн дадлагыг аймгуудын БОАЖГ, БОНБУ-ний компаниуд дээр хийж тайланг хамгаалав.
- ✓ Оюутнуудын дунд сэдэвчилсэн дугуйлангууд үргэлжлэн ажиллав.
- ✓ МУИС, МУБИС–иудтай хамтран Шведийн хөгжлийн сангийн дэмжлэгээр “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийг хэрэгжүүлж дуусав. Төслөөр тус сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох санал, санаачлагыг гаргаж зохих арга хэмжээ авав.

2011–2012 оны хичээлийн жил:

- ✓ Эко Ази Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн үүсгэн байгуулагч, захирал доктор, профессор **Ц.Адъяасүрэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Байгаль орчны гавъяат ажилтан цол** хүртэв.
- ✓ Тус сургуулийн багш, судлаачид ГХГЗЗГ-ын захиалгаар Хэнтий аймгийн хот, тосгон бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.
- ✓ БСШУЯ-ны захиалгаар Улаанбаатар хотын Багануур дүүрэгт байгуулах Их сургуулиудын нэгдсэн хотхоны байгаль орчны судалгааг хийж гүйцэтгэв.
- ✓ Тус сургуулийг төгссөн **н.Амарзаяа** 2011 оны улсын наадмаар Тав давж **Монгол улсын начин цолны болзол** хангасан байна.
- ✓ БОАЖЯ-ны Ойн газар, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын “Ойн менежмент” төсөлтэй хамтран хамтын эзэмшлийн ойн менежментийн агуулгаар “Ойн хичээл”-ийн хөтөлбөрийг өргөжүүлж, холбогдох гарын авлага, сурах бичиг зохиох, чадавхийг бий болгох талаар “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- ✓ Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт Салхит уулын орчим байгуулах “Салхин парк”-ын төслийн байгаль орчны судалгааг хийлээ.
- ✓ Монголын Оюутны Холбоотой хамтран доктор, проф. Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит уламжлалт оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн 9 дэх удаагийн ЭШБХ-ыг “Экологи, тогтвортой хөгжил” сэдвээр зарлаж, шалгаруулав.
- ✓ Тус сургуулийн захирал доктор, профессор Ц.Адъяасүрэнгээр ахлуулсан баг ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх төсөлтэй хамтран “ТХГН-ийн Үндэсний форум” зохион байгуулах ажлын хүрээнд Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажлыг хариуцан амжилттай зохион байгууллаа.
- ✓ Швейцарийн хөгжлийн агентлагийн Бичил уурхай төөлтэй хамтран Хувиараа ашигт малтмал эрхлэгч иргэдэд зориулсан байгаль орчны сургалтыг зохион байгуулж, холбогдох тайлан, гарын авлага боловсрууллаа.
- ✓ “Байгаль орчны аудит”-ын хээрийн даплага зохион байгуулав.
- ✓ “Байгаль орчны аудитын гарын авлага” боловсруулж, хэвлүүлэв.
- ✓ “Байгаль орчны аудит”-ын анхны мэргэжилтэнүүдийг сургаж бэлтгэв.
- ✓ “Greenpreneur 2011”-ийн “2011 оны Онцлох экологийн боловсрол олгогч” байгууллагаар Эко Ази дээд сургууль шалгарч Хүндэт өргөмжлөл хүртэв.
- ✓ ШУА-ын эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд Ц.Адъяасүрэн “**Монгол улсын ногоон хөгжлийн ирээдүй**” сэдэвт илтгэлээр оролцож тэргүүн байр эзлэв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн “Дэлхийн ирээдүй ба ногоон хөгжил” сэдэвт илтгэл боловсруулж олон улсын хуралдаанд илтгэв.
- ✓ БНСУ-ын Соёлын өвийн сангийн дэмжлэгээр “Булган аймгийн Дашинчилэн сумын тогтвортой хөгжлийн хөтөлбөр” боловсруулж батлуулав.
- ✓ АХБ-ны дэмжлэгээр “Дундговь аймгийн Баянцагаан суманд бэлчээрийн менежментийн төсөл” судалга, тусламжийн ажлыг эхлүүлэв.
- ✓ Тус сургуулийн багш нар Дэлхийн банкны дэмжлэгээр “Ховд, Өмнөговь, Увс аймгийн байгаль орчны мэргэжилтэнүүдийн чадавхийг сайжруулах” төсөл, судалгааны ажлыг гүйцэтгэж дээрхи аймгуудад хэд хэдэн удаа сургалтууд зохион байгуулав.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн МБОИЗ-ийн 2011 оны “Эко Элч”-ээр шалгарч Хүндэт цом хүртэв.

2012–2013 оны хичээлийн жил:

- ✓ 2012 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас “Green Awards 2012” буюу “Ногоон” манлайлалын эздийг тодруулах арга хэмжээг анх удаа зохион байгуулж, Green Awards-ын Гран при шагналын эзнээр “Эко Ази” Айгаль орчны менежментийн дээд сургууль шалгарлаа.

- ✓ Тус сургууль нь 2012 оны 6 дугаар сард Боловсрол, шинжлэх ухааны яамны аттестатчилалд орж амжилттай дүн үзүүлээ.
- ✓ Ойн үндэсний бодлого форумд оролцож шатсан ойг огтолж болохгүй талаар санал дэвшүүлж, Солонготын давааны ойг аврав.
- ✓ Эко Ази БОМДС-ийн удирдлага, ТНС олон улсын байгууллагын урилгаар Хойд Америкийн Байгаль хамгаалах бүс нутгийн тусгай консул Philip Tabas тус сургуулийн багш оюутнууд болон ГХГЗЗГ-ын удирдлага, албан хаагчдад “АНУ-д газрыг өмчлөх, түүнд хяналт тавих, хамгаалах эрх зүйн орчин” сэдвээр лекц уншлаа.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн “Дэлхийн ирээдүй ба ногоон хөгжил” сэдэвт илтгэлийн оюутануудад танилцуулав.
- ✓ 2012-2013 оны хичээлийн жилээс эхлэн тус сургуульд дараах мэргэжлээр сургалт явуулах боллоо.
 - Байгаль орчны нөхөн сэргээлт
 - Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт.
- ✓ Тус сургуулийг төгсөгчдөөс “Эрдэнэт” Уулын баяжуулах үйлдвэр, Өмнөговь аймгийн таван толгойн “Энержи ресурс” ХХК-д, Монполимет нүүрсний уурхай зэрэг олон үйлдвэр аж ахуйн нэгжид тус сургуулийг төгсөгчид байгаль орчны менежментийн чиглэлээр амжилттай ажиллаж эхлэв.
- ✓ Тус сургуулийн багш, судлаачид, оюутнууд 2012 оны 6-9 дүгээр сард Хэнтий аймгийн Байгаль орчны газрын захиалгаар тус аймгийн “Нэн ховор, ховор, ашигт ургамалын судалгаа”-ны ажлыг амжилттай гүйцэтгэж мэдээллийн сан байгуулж, тэдгээрийн нөөцийг тогтоох ажлыг гүйцэтгэлээ.
- ✓ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захиалгаар “Сүхбаатар, Дорноговь, Төв, Өвөрхангай аймгийн 13 суманд хэрэгжиж байгаа “Цөлжилтийг сааруулах бэлчээрийн менежментийг сайжруулах” төслийн үнэлгээ, шалгалтын ажлыг 2012 оны 7-9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн байна.

2013-2014 оны хичээлийн жил:

- ✓ 2013 оны 10 дугаар сард БОНХЯ-ны байгаль хамгаалах сарын аяны хүрээнд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран “Цэвэр агаар, эрүүл орчин” сэдэвт арга хэмжээнд оролцов.
- ✓ 2013 оны 10 сард Сагсан бөмбөг, гар бөмбөгийн сургуулийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав .
- ✓ 2013 оны 10 сарын 29-нд Зууны лекцийн цагаар Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан, музейн тайлбарлагч, магистр Д.Оргилыг урин ирүүлж Улаанбаатар хотын түүх соёлын дурсгалын талаар оюутнуудад сонирхолтой лекц уншууллаа.

- ✓ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын зөвлөх, Эко Ази Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн захирал Байгаль орчны гавъяат ажилтан, доктор, проф. Ц.Адъяасүрэн, Удирдах зөвлөлийн дарга профессор. Ц.Дамдин нар Монгол–Солонгосын форумд оролцов.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн ШУА-ийн “Геологи–Газар зүйн Бага чуулган”-ны гишүүнээр сонгогдов.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн Казакстан улсад “Казакстан улсын Эдийн засгийн форум” оролцож “Монгол орны ногоон хөгжилийн хөтөлбөр” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.
- ✓ Судлаач Ц.Адъяасүрэн, Б.Уртнасан, Ч.Төмөрбаатар, Д.Одонцэцэг, Ю.Амаржаргал нар “Хэнтийн Улз гол, Хөх нуурын бэлчээрийн төлөв байдлын судалгаа, үнэлгээ” төсөлт ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгөв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн Тайванд “Азийн бүтээмжийн 3 дугаар бага хурал”-д оролцож “Монгол орны ногоон хөгжил” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.
- ✓ 2014 оны 03 сард Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны багш нарт “Байгаль орчин-ногоон хөгжил” сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалтыг Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв, Нийслэлийн Боловсролын газартай хамтран зохион байгууллаа.
- ✓ 2014 оны 04 сарын 15-нд доктор профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил, байгаль орчин” сэдэвт их дээд сургуулийн мэргэжлийн ангийн оюутнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа. Тус хурлын ивээн тэтгэгчээр Монголын оюутны холбоо, Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв, “Эко ревивал” ХХК, тохижилт ногоон байгууламжийн “Форест докторс” ХХК, Байгаль орчны үнэлгээний “Ойт бүс” ХХК, “Төгөл-сүмбэр чойр” ТББ байгууллага хамтран ажиллав.
- ✓ 2014 оны 04 сарын 24-нд Нийслэлийн Боловсролын газартай хамтран ЕБС-ийн сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчныг хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах, тэдний санал бодлыг сонсох, олон нийтийн хүртээл болгох зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг. Экологийн III олимпиадыг зохион байгууллаа.
- ✓ 2014 оны 06 сарын 05-нд Ногоон хөгжлийн үндэсний анхдугаар чуулганд Эко-Ази БОМДС-ийн захирал доктор профессор Ц.Адъяасүрэн, сургалтын менежер Г.Чулуунцэцэг, сургалтын албаны дарга А.Эрдэнэбаяр нар оролцлоо.

2014-2015 оны хичээлийн жил:

- ✓ 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Эко Ази дээд сургууль, БНСУ-ын “Ногоон Ази сүлжээ” ТББ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

- ✓ 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдөр “Ногоон Ази сүлжээ” ТББ-ын цөлжилтийг сааруулах ойжуулалтын талбайн нэг болох Төв аймгийн Эрдэнийн талбайд бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан “Ногоон наадам” хүндэтгэлийн арга хэмжээнд ЭКО АЗИ дээд сургуулийн удирдлага, багш, оюутнууд оролцов.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн “Монгол улсын Эдийн засгийн форум”-д оролцож ойг хамгаалах асуудлаар санал дэвшүүлэв.
- ✓ ГХГЗЗГ-ын захиалгаар “Монгол орны 1:500000 масштабтай уур амьсгалын зураг боловсруулах” төсөлт ажлыг гүйцэтгэв.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн. “Монгол орны уур амьсгалын өөрчлөлт цэвэр агаарын уулзалт”-д оролцож тодорхой асуудлаар санал дэвшүүлэв.
- ✓ Тус хичээлийн жилээс эхлэн тус сургуульд дараах мэргэжлээр сургалт явуулах боллоо.
 - Хүрээлэх орчин судлал
 - Байгаль орчны ашиглалт, үнэлгээ
- ✓ Тус сургуулийн багш, оюутнуудад 2014 оны 9 дүгээр сарын 14-нд Озоны давхаргыг хамгаалах олон улсын өдөрт зориулж захирал Ц.Адъяасүрэн “Гараг Дэлхийдээ бидний өргөх бидний хувь нэмэр” сэдэвт лекц уншлаа.
- ✓ Эко Ази дээд сургуулийн магистрийн багш доктор **З.Батжаргал Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Байгаль орчны гавъяат ажилтан цол** хүртэв.
- ✓ Төгсөлтийн дараах сургалт болох **Магистрийн сургалт 2014 оны 10 сарын 06-наас нээлтээ хийж** анхны магистрантуудаа Хүрээлэх орчин судлал, Байгаль ашиглалт хяналт үнэлгээ, Газар зохион байгуулалт ангидаа бүртгэж өдрийн сургалтаар 1,5 жилээр сургаж эхллээ.
- ✓ БОАЖЯ, ТХНУГ-аас зохион байгуулсан “ТХГН-ийг хэн сайн мэдэх вэ” сэдэвт танин мэдэхүйн уралдаанд Эко Ази БОМДС-ийн ЭБХ, БОХУ-ний ангийн оюутнууд оролцож, уралдааныг хошуучилж тэргүүлэн, үнэ бүхий зүйл зургийн аппаратаар шагнууллаа.
- ✓ Манай сургуулийн жил бүр сар болгонд зохион явуулдаг багш нарын онолын семинарт Азжаргал багш “Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, түүнтэй тэмцэх нь”, захирал доктор, профессор Ц.Адъяасүрэн “Монгол орны 1:500000 масштабтай уур амьсгалын карт зохиох, холбогдох мэдээллийн сан байгуулах судалгааны ажил”, 2015 оны 1 сард А.Цэнд-Аюуш багш “Мөнххайрхан дэд мужийн хөрсний хэв шинж” сэдэвт, М.Амаржаргал “Ургийн бичиг хөтлөх арга, түүний ач холбогдол” сэдвээр тус тус илтгэл илтгэлээ.
- ✓ Газрын харилцаа үүсч хөгжсөний, Газар зохион байгуулалтын 60 жилийн ойн медалиар 2014 оны 10 сарын 30-ны өдөр багш Ж.Баянмөнх, Б.Батсүрэн, Б.Ууганцэцэг, А.Цэнд-Аюуш нар тус тус шагнагдлаа.

- ✓ Экологи байгаль хамгаалалын /эчнээ/ 3 ангийн оюутан Шижирбаатар “Байгаль хамгаалагчийн ажил үүрэг, хариуцлага” сэдэвт практик хичээл явууллаа.
- ✓ БСШУЯ-наас хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах даалгавар өгсөний хүрээнд Экологи-байгал хамгаалал, Байгаль орчны хяналт үнэлгээ, газар зохион байгуулалтын хичээлийн хөтөлбөр тус тус шинэчлэгдэн боловсруулсан.
- ✓ Жил бүр зохион байгуулдаг Байгаль орчны гавьяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил-Байгаль орчин” сэдэвт оюутны улсын эрдэм шинжилгээний 11-р бага хурал 2015 оны 04 сарын 15-нд болж өндөрлөлөө.
- ✓ МУИС-ийн Экологийн олимпиадад докторант Э.Мөнхжаргал багш шүүгчээр, ЭБХ-2, 3 курсын оюутнуудтай оролцлоо.

2015–2016 оны хичээлийн жил:

- ✓ 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ХБОС, БОХУ-ний хөтөлбөрийн анхны 7 магистрант эрдэм шинжилгээний ажлаа амжилттай хамгаалж, анхны магистрын сургалтын төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулав.
- ✓ 2016 оны 2 дугаар сарын 03-нд тус сургуулийн Удирдах зөвлөл болон Эрдмийн зөвлөлийн өргөтгөсөн хурал болж, тус хурлын шийдвэрээр Эко Ази дээд сургуулийн Удирдах зөвлөлийн дарга Байгаль орчны гавьяат ажилтан проф.Ц.Дамдин, эрдмийн зөвлөлийн гишүүн Байгаль орчны гавьяат ажилтан доктор, проф.З.Батжаргал, эрдмийн зөвлөлийн гишүүн Байгаль орчны гавьяат ажилтан доктор.Б.Чимэд, эрдмийн зөвлөлийн гишүүн доктор Д.Энэбиш, эрдмийн зөвлөлийн гишүүн доктор Б.Мижиддорж, эрдмийн зөвлөлийн гишүүн дэд проф.Д.Содном нарт сургуулийн **Эко Ази дээд сургуулийн профессор цол**, Гүйцэтгэх захирал А.Ган-Өлзий, Сургалтын албаны дарга Г.Чулуунцэцэг, эрдэм шинжилгээний ажилтан багш Б.Уртнасан, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр нар **дэд профессор** цол тус тус олголоо.
- ✓ Эко Ази БОМДС, БОАЖЯ-ны Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран ЕБС-ийн ахлах ангийнхны дунд “Монгол улсын Улаан номыг хэн сайн мэдэх вэ” сэдэвт танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг зохион байгууллаа.
- ✓ Тус сургуулийг төгссөн **н.Ванданцэрэн** 2016 оны улсын наадмаар Тав давж **Монгол улсын начин цолны болзол** хангасан байна.
- ✓ Эко Ази дээд сургуулийн магистрийн багш доктор, профессор **Б.Чимид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Байгаль орчны гавьяат ажилтан цол** хүртэв.

- ✓ Жил бүр зохион байгуулдаг Байгаль орчны гавьяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил-Байгаль орчин” сэдэвт оюутны улсын эрдэм шинжилгээний 12-р бага хурал амжилттай болж өндөрлөлөө.
- ✓ Монгол Улсын бокс, чөлөөт бөхийн шигшээ багийн гишүүн, Эко Ази Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн **Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөрийн ангийн оюутан олон улсын хэмжээний мастер Д.Отгондалай** Риогийн олимпд боксын 60 кг-ын жинд амжилттай өрсөлдөж эх орондоо **хүрэл медаль** авчирлаа.
- ✓ Тус сургуулийн мэргэжлийн ангийн оюутнууд БНСУ-ын Ногоон Ази ТББ-ын Булган аймгийн Дашинчилэн суманд орших ойжуулалтын талбайд дадлага хийв.
- ✓ Эко Ази БОМДС 2016 оны 4 дүгээр сарын 28-нд “Монголын хувийн их, дээд сургуулийн холбоо”-г бусад их, дээд сургуулиудтай хамтран байгуулж, гишүүн байгууллагаар бүртгүүлээ.
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт, ЭТДЗ-хуйн боловсрол” 2 кредит цагийн сургалтын хөтөлбөрийг дагалдан гарах гарын авлагыг боловсруулах, зорилтот 17 сумын дунд сургуулийн багш нарт сургалт зохион байгуулж, холбогдох гарын авлага боловсрууллаа.
- ✓ Хангайн нурууны Байгалийн цогцолбор газрын Захиргаа үүсэж байгуулагдсаны 20 жилийн ойн Эрдэм шинжилгээний бага хуралд тус сургуулийн Ерөнхий захирал доктор, профессор Ц.Адъяасүрэн, Ерөнхий менежер дэд профессор А.Эрдэнэбаяр нар Захиргааны Удирдлагатай хамтран “Хангайн нурууны Байгалийн цогцолбор газар 20 жил: түүхэн хөгжил, судалгаа шинжилгээ, хэтийн төлөв” сэдэвт илтгэл бэлтгэж хэлэлцүүлсэн.

2016-2017 оны хичээлийн жил:

- ✓ Эко Ази БОМДС-ийн захирал доктор, профессор **Ц.Адъяасүрэн** **“Монголын төрд зүтгэсэн 40 жил”** сэдэвт дурсамж лекцийг зохион байгууллаа.
- ✓ БНСУ-ын “Дегу Гёнбуг” сэтгэлийн боловсрол төвийн лектор Ган Сан Че тус сургуулийн багш, оюутнуудад “Сэтгэлийн боловсрол” лекцийг уншлаа.
- ✓ Жил бүр зохион байгуулдаг Байгаль орчны гавьяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил-Байгаль орчин” сэдэвт оюутны улсын эрдэм шинжилгээний 13-р бага хурал амжилттай болж өндөрлөлөө.
- ✓ Усны салбар үүсч хөгжсөний 79 жилийн ой, дэлхийн усны өдөр “Хаягдал ус-Нөөц баялаг” уриан дор “Ус хөгжлийн түлхүүр” сэдэвт ЭШБХ зохион

байгуулагдаж, тус сургуулийн багш оюутнууд оролцож, ЭБХ-4 ангийн оюутан Н.Ганбаяр тэргүүн байр эзэллээ.

- ✓ Германы хамтын ажиллагаа, БОНХАЖЯ-ны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд “Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн бэлчээрийн тогтвортой менежментийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгаа хийх мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх” ажлын хүрээнд Орхоны хөндийн БЦГ, Хангайн нурууны БЦГ, тарвагатайн нурууны БЦГ, Улаантайгын ДЦГ, Дорнод Монголын ДЦГ, Тосон Хулстайн БЦГ, Хустайн БЦГ зэрэг 8 ТХГН-ийн бэлчээрийн суурь судалгааг хийж гүйцэтгэлээ.
- ✓ БОАЖЯ, UN-REDD хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжтэй хамтран Ойн доройтол хомсдолоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад оролцогч талуудыг тодорхойлж, салбар бүрээр дүн шинжилгээг хийж, сургалт, семинар зохион байгууллаа.
- ✓ БОАЖЯ-ны “Байгаль орчны салбарын ажилтан нарт Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар сургалт явуулж, сургалтын хөтөлбөр боловсруулах, гарын авлага бэлтгэх зөвлөх үйлчилгээний ажил” гүйцэтгэв.

2017–2018 оны хичээлийн жил:

- ✓ 2017 онд, БОАЖЯ-ны “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээ”-г /Зүүн бүс: Хэнтий аймгийн Хурх-Хүйтний хөндий, Тэнүүн голын БНГ, Хар Ямаатын БНГ, Онон Балжийн БЦГ, Ноён хангайн БЦГ/ ажлыг хийж гүйцэтгэлээ.
- ✓ Тус сургуулийн БОХУ, ХБОС-ын хөтөлбөрийн магистрын ангийн оюутнууд Хустайн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай танилцлаа.
- ✓ Жил бүр зохион байгуулдаг Байгаль орчны гавьяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил-Байгаль орчин” сэдэвт оюутны улсын эрдэм шинжилгээний 14-р бага хурал амжилттай болж өндөрлөлөө.
- ✓ Монгол улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулсан “Тогтвортой хөгжил-Дээд боловсрол” улсын 2-р зөвлөгөөнд тус сургуулийн удирдлага, багш нар оролцож, санал солилцлоо.
- ✓ БОАЖЯ, Германы хамтын ажиллагааны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд “Орхоны хөндийн БЦГ, Зэд Хантай Бүтээлийн нурууны ДЦГ, Хөгнө Тарнын БЦГ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, өмнөх менежментийн төлөвлөгөө (2014-2018)-ний биелэлтэд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.

2018–2019 оны хичээлийн жил:

- ✓ МУБИС–иудад зориулан 2018 оны 9 дүгээр сарын 12-нд захирал Ц.Адъяасүрэн “Озоны давхаргыг хамгаалах олон улсын хүчин чармайлт” сэдэвт лекц уншив.
- ✓ НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Монгол улсын авто тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээний суурь судалгаа – авто тээврийн хэрэгслийн ялгаруулалтын стандарт болон түлшний чанарыг сайжруулах замын зураг гаргах” ажлыг гүйцэтгэв.
- ✓ 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдөр БОАЖЯ, БОАЖЯ-ны Озоны Үндэсний алба, байгаль орчны үнэлгээний Санни трейд компанитай хамтран “Байгаль орчны салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж” аж ахуйн нэгж, компанийн ажилтан нарт зориулсан семинарыг зохион байгууллаа.
- ✓ Жил бүр зохион байгуулдаг Байгаль орчны гавьяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгийн нэрэмжит “Ногоон хөгжил-Байгаль орчин” сэдэвт оюутны улсын эрдэм шинжилгээний 15-р бага хурал 2019 оны 4 сарын 19-ний өдөр амжилттай болж өндөрлөлөө.
- ✓ “Эко Ази “Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн захирал, доктор, профессор Ц.АДЪЯАСҮРЭН “МОНГОЛЧУУДЫН ҮНЭТ ЗҮЙЛС БА БАЙГАЛЬ ОРЧИН” сэдэвт лекц уншлаа.
- ✓ Тус сургуулийг төгссөн **н.Ганбат** 2018 оны улсын наадмаар Архангай аймагт түрүүлж **Аймгийн арслан цолны болзол** хангасан байна.

2019–2020 оны хичээлийн жил:

- ✓ 2019 онд Сүхбаатар аймгийн БОАЖГ, “Сүхбаатар аймгийн тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Баянцагааны тал, Дарханхаан уул, Лхачинвандад уул, Шилийн Богд уул, Хөргийн хөндий, Онгон таван булгийн ТХГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, Сүхбаатар аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлууллаа.
- ✓ НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Монгол улс дахь тээврийн хэрэгсэлийн ялгаруулалтын стандарт ба түлшний чанарын стандартыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх бодлогын судалгаа”-ны ажлыг гүйцэтгэж эхлэв.
- ✓ БСШУЯ-ны шийдвэрээр тус сургууль “Улаанбаатар Эрдэм” Их сургуулийн харьяа Эко Ази байгаль орчны менежментийн дээд сургууль сургууль болон ажиллах болов.
- ✓ Эко Ази Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн 2017 оны төгсөгч, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын харьяат **Д.Төрболд** 2020 оны наадмаар **Аймгийн арслан цолны болзол** хангалаа.

- ✓ Европын холбооны ERASMUS төслийн хүрээнд “ТХГН-ийн Экосистемийн үйлчилгээний мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр магистрийн сургалт явуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах ECOSERVE төсөл”-д оролцохоор шалгарлаа.

2020–2021 оны хичээлийн жил:

- ✓ Европын холбооны ERASMUS төслийн санхүүжилттэй хэрэгжих “ТХГН-ийн Экосистемийн үйлчилгээний мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр магистрийн сургалт явуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах” төсөлд оролцож эхлэв.
- ✓ “Сайхан Монгол орон” баримтат кино бүтээх төсөл санаачилж “Монгол орны тал нутгийн тахилгат, шүтээн газар нутаг” хоёр ангит баримтат кино бүтээж, ТВ9 телевизээр гаргав.
- ✓ Эко Ази Байгаль орчин, менежментийн дээд сургуулийн 2017 оны төгсөгч, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын харьяат **Д.Төрболд** 2021 оны наадмаар **Монгол улсын начин цолны** болзол хангалаа.

2021–2022 оны хичээлийн жил:

- ✓ ERASMUS төслийн хүрээнд Эко Ази дээд сургуулийн вэб хуудасыг шинэчлэн сайжруулав
- ✓ БОАЖЯ, ХБНГУ-ын KfW банк, GIS ны дэмжлэгтэй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд ”Бэлчээрийн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлтэд мониторинг, үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэж тайлан боловсруулав.
- ✓ Захирал Ц.Адъяасүрэн “Тахилгат нутаг ба уул уурхай зохилдохуй” сэдэвт илтгэлийг “ЮНЕСКО-ийн батламжит Байгаль соёлын өвийн сангийн ээлжит хуралдаан” -нд хэлэлцүүлэв.
- ✓ Европын Холбооны Эрасмус+ хөтөлбөрийн санхүүжилттэй “Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээ, менежмент”-ийн чиглэлээр олон улсын магистрын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх “ECOSERVE” төслийн хүрээнд Эко Ази дээд сургуулийн захирал, төслийн удирдагч Байгаль орчны гавъяат ажилтан, доктор, профессор Ц.Адъяасүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Улаантайгын Улсын Тусгай Хамгаалалттай Газар нутгийн Хамгаалалтын захиргааны хариуцан хамгаалдаг Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд орших УТДЦГ, Хорьдол Сарьдагийн нурууны ДЦГ, Цагаан нуур суманд орших Тэнгис-Шишхидийн голын сав газрын БЦГ-т 2021 оны 10 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд ажиллаж, төслийн сургалт семинар зохион байгууллаа.
- ✓ БОАЖЯ, ХБНГУ-ын KfW банк, GIS ны дэмжлэгтэй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн

- хүрээнд "Баруун бүсийн ТХГН-уудын үр ашигт байдлын үнэлгээ" зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэхээр шалгарав.
- ✓ Тус сургуулийн Удирдах зөвлөлийн дарга, "Улаанбаатар Эрдэм" Их сургуулийг үүсгэн байгуулагч, **Академич Т.Дорж** Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар **Монгол улсын Ардын багш** эрхэм цол хүртэв.
 - ✓ Эко Ази дээд сургууль үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойд зориулан Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
 - ✓ Эко Ази дээд сургууль үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойд зориулан "Бидний Эко Азичууд 20 жилд" ном хэвлүүлж, баримтат кино бүтээв.